



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/345

Мандалговь

У.Мөнхчулуунд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.7, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4 дэх заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 09 дугаар сарын 02-ны өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайхан-Овоо сумын уугуул Улаанхүү овогтой Мөнхчулуунг Узбекистан Улсын Ташкент хотод зохион байгуулагдах 2021 оны Насанд хүрэгчдийн Белбогли Кураш бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 1,000,000 (Нэг сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111154